

МОНГОЛЫН ТҮҮХИЙН НЭР ХҮНДИЙГ ӨРГӨХ БОЛОМЖ БИЙ ЮУ

С.Отгонжаргал

Монгол Улсын Их Сургууль, Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль, Түүхийн тэнхим

Өгүүллийн товч: Монголын түүхийн нэр хүндийг өргөх гагц боломж нь түүхийн гүн ухаан мөн гэдгийг онолын үүднээс батлахыг оролдсоны дээр уг өгүүлэлдээ Монголын түүхийг Ерөнхий боловсролын сургууль, Их дээд сургуулиудад зааж байгаа төвшинг тодорхойлох оролдлого хийсэн болно.

Түлхүүр үг: Түүхийн гүн ухаан, “Ухаан”-ы тухай идеалист метафизик, “Оюун санаа”-ны метафизик, мета түүх, нигилизм, субстанц, историзм, историцизм, үйл явдал, үйл явц.

XVIII зууны үед дэлхий дахинаа түүхийн нэр хүнд унаж түүхийн мөхлийн тухай бүхэл бүтэн урсгал гарч ирсэн нь түүхчдэд харангын дохио өгсөн юм. Өчигдрийн буюу өнгөрсөн баларсан бидэнд хэрэггүй, маргаашаараа амьдарцгаа гэж олон түмнийг уриалах нь ч ердийн үг хэллэг болсон байв. Энэ бол хүн төрөлхтнийг мөхөөх аюулт урсгал байсан юм. Энэ хүнд үед түүхийн шинжлэх ухааныг аврах агуу том гарцыг гүн ухаанчид олж харжээ. Түүхийн гүн ухаан гэдэг нэр томъёог анхлан Францын нэрт соён гэгээрүүлэгч Вольтер өөрийн бүтээлдээ хэрэглэсэн юм. Тэрээр түүхчид түүхийг зөвхөн болсон байдлаар нь бичих, цаг үеэр нь дурьдах биш харин гүн ухааны эргэлтэнд оруулж боловсруулах ёстой хэмээн үзэхдээ метафизикийн асуудлыг гаргаж тавьжээ. Вольтерийн энэхүү гайхамшигт санааг Германы гүн сэтгэгч Гердер улам хөгжүүлж, эрдэм шинжилгээний эргэлтэнд оруулсан байна. “Хүн төрөлхтний мэлмийг нээх гэж түүхийн гүн ухаан бий болсон” гэсэн Гердерийн үг дэндүү ончтой үг байлаа. Тэрээр аливаад хандах стереотипийг үгүйсгэж хувь хүний мэдрэмж, агуу их олон талт бүтээлч чанарт ач холбогдол өгч байв. Амьд ба амьгүй байгалд ажиглалт хийж, хүний түүх нийгмийн амьдралыг бүхэлд нь нэгдмэл авч үзсэнээр дэлхийн органик хөгжлийн үзэл бодлыг бий болгож үүнийгээ хүлээн зөвшөөрөгдсөн урсгал болгож чадсан байна. Гердер дэлхийн нэгдмэл организмын үзлийг бий болгосноороо шашны өнгө аястай түүхийн ойлголтыг үгүй болгож чаджээ. Удаж төдөлгүй түүхийн гүн ухааны асуудлыг Гегель хөндөж тавьснаар араасаа олон гүн ухаанчдыг дагуулсан байдаг. Тэрээр “Ухаан”-ы тухай идеалист метафизикийг “Оюун санаа”-ны метафизик руу шилжүүлснээр түүхийн үйл явцын тухай ойлголтыг илүү нарийсгаж түүхэн үйл явцыг тээж авч явагч нь “бодит оюун санаа” мөн болохыг нотолсон юм. Бодит оюун санаа нь оршихын дээд зэргийн хэлбэр мөн гэж үзэхийн зэрэгцээ оюун санаа гэдэг бол “Бүх юм” түүгээр ч зогсохгүй дэлхийн түүхийн үйл явцыг удирдан чиглүүлэгч нь хэмээн үзсэн байна. Ухааны субстанц нь эрх чөлөө, тийм ч учраас түүхийн эцсийн зорилго нь эрх чөлөө хэмээн гайхамшигт дүгнэлтээ хийжээ. Ийм ч учраас эрх чөлөөг ухамсарлах нь даян дэлхийн түүхийн дотоод хууль мөн гэж үзсэн байна. “Түүхэн үйл явц” “Үнэн” хоёр бүхэлдээ нэг нэгэнтэйгээ тохирч байх ёстой. Үнэн гэдэг бол нэгдмэл бүхэл бүтэн юм болно. Иймээс түүх бол ямар нэгэн юм биш харин дэлхийн шүүх нь болж байдаг гэжээ. Гегель энэ үзлээ шинжлэх ухаанчаар батлаж чадсанаар түүхийн шинжлэх ухаанд болон түүхийн гүн ухааны салбарт агуу том нээлт хийсэн юм. Гегелийн онолын субстанц нь үүнд оршдог юм. Маркс ч түүхийн гүн ухаанд өөр чиглэл, өөр урсгалыг бий болгож, түүхийн гүн ухааныг хөгжүүлэхэд томоохон хувь нэмэр оруулжээ. XIX зуун болоход түүхийг үзэх рационалист, оптимист, материалист үзлийн зэрэгцээ Ф.Ницшегийн иррационалист, нигилист үзэл өөрийн гэсэн өнгө аястай урсгал болон орж ирэв. XX зуун болоход гүн ухаантнуудын дунд түүхийн гүн ухааныг хэт өөдрөг харах

үзлийг эрс эсэргүүцсэн бас нэгэн том урсгал бий болов. Хэдийгээр түүхийн гүн ухаан нь олон ургальч үзлийг хүлээн зөвшөөрдөг ч хэт өөдрөг үзэл нь уршиг авчрах талтайг нотлож эхлэв. “Натураль өнгөгүй зургийг бид нүдээ анин өнгөтэйгээр харж болох хэдий ч өөрийн өнгө аястай, өөрийн амьдралтай, өөрийн хүсэл эрмэлзэлтэй, өөрийн үхэлтэй, өнгөгүй бүүдгэр тэр зураг байгаагаараа л үлдэнэ” гэж Освальд Шпенглер үзэж байлаа. Германы энэхүү суут сэтгэгчийн үзлийг гүн ухаанчид дэмжин хүлээж авсан байна. Ийнхүү XYIII- XIX зууны эхэн үе хүртэл түүхийн гүн ухаан нь түүхийн хөгжлийн ерөнхий онолоор явж, гүн ухаанчид түүхэн үйл явцын утга учир, хөдөлгөгч хүчний зорилгыг тодорхойлоход гол анхаарлаа хандуулж байв. Түүхийг удирдаад залаад байгаа тэр хүч юу вэ гэсэн асуултанд нэг хэсэг нь бурхан гэж хариулж байхад нөгөө хэсэг нь хүний оюун ухаан хэмээн хариулж өөр өөрийнхөөрөө л тайлбарлаж байв. Ницшегийн нигилист үзэл” нийгэм-соёлын чиглэлээр илрэлээ олж нийгмийн буюу түүхэн уламжлалт итгэл үнэмшил нь дэндүү хуурмаг, орших үндэсгүй гээд шинэ итгэл үнэмшлийн асуудлыг хөндөж тавив. Тэрээр “Бурхан үхсэн” гэсэн алдарт үгээ хэлснээр түүхийн хүрдийг Бурхан эргүүлж байгаа гэсэн хуучин үнэт зүйлсийг үнэгүйдүүлж чадсан юм. Хүн төрөлхтний бий болгосон бүхий л үнэт зүйлсийг дахин үнэлэх эрин үе ирсэн гэдгийг ойлгуулснаараа хүний тархи, оюун ухааныг асар том хөдөлгөөнд оруулсан юм. Хүмүүс хоорондоо ганц зүйлээр л ялгагддаг. Нэг хэсэг нь байгалаасаа сул дорой төрдөг. Тэд бол “боолууд”. Нөгөө хэсэг нь хүчтэй төрдөг. Тэд бол эзэд юм. Тэгшитгэнэ гэдэг нь мөхөл юм гэснээрээ утоп социалистуудын хүсээд байгаа нийгэм эцсийн эцэст мөхлийг авчирна хэмээн үзсэний дээр түүхийн хүрдийг бурхан биш хүчтэнгүүд хөдөлгөдөг юм гэсэн алдарт санаагаа зоригтой дэвшүүлсэн байдаг. Ф.Ницше “эргэж санах юмгүй яг одоо цаг дээрээ байдаг нь малын онцлог. Мал зөвхөн өвсөө л хивнэ. Түүнд өчигдөр өнөөдөр хамаагүй, гэтэл хүнд түүхэн ба түүхэн бус бүх зүйл хамаатай байдаг. Гэхдээ хүн бүр түүхийн бүрэн дүүрэн мэдлэгтэй байдаггүй учраас өөрийн хийсэн бүхнийгээ нээлт буюу шинэ юм гэж бодож, өөрөө өөртөө буруу ойлголт төрүүлж байдаг. Хүн түүхэн биш зүйлтэй холбогдохдоо бодох, сэтгэх, харьцуулах, салгаж, холбож л байж түүхэн биштэй холбогддог. Хүн ерөөсөө өнгөрснийг байнга ашиглах замаар одоог түүх болгож байдгаараа жинхэнэ хүн болдог. Түүхгүйгээр хүн ерөөс хүн байхаа больдог. Хүний оршин байх нөхцөл нь ч ийм байдаг. Хүн байхгүй болоход л түүх ч үгүй болно. Түүхгүйгээр хүн үл оршино. Түүх хүний амьдралын үйлчлэгч нь юм. Тийм учраас амьдрал түүхээр байнга цангаж байдаг” гэжээ. Ф.Ницше түүхийн гүн ухаан дахь нигилизмын урсгалыг бий болгосон байна. Гүн ухааны олон эрдэмтэд түүхийн шинжлэх ухааныг хөгжүүлэх арга замыг хайх явцдаа түүхийн метафизик чанар болон түүх мета байхын дээр субстанцлаг чанартай болохыг нээсэн байна. Түүгээр ч зогсохгүй шүүмжлэлт түүхийн гүн ухааны асуудлыг хөндөж түүхэн үйл явцын зүй тогтлыг нээжээ. Ингэж хүн төрөлхтний нийгмийн хөгжлийн хөдлөшгүй байнгын тогтсон хууль гэж байна уу? Байгаа бол тэр нь ямар хууль юм бэ? гэсэн мөнхийн асуултанд хариулт өгч чадсан байна. Хэрэв гүн ухаан “Би хэн бэ” гэж эхэлдэг бол түүхийн гүн ухаан нь “Бид хаашаа явж байгаа юм бэ, хөгжиж байна уу мөхөж байна уу? Түүхийн хүрдийг юу эргүүлдэг юм бэ? Бурхан юм уу аль эсвэл?, нийгмийн хөгжлийн хөдлөшгүй байнгын тогтсон хууль гэж байна уу? Байгаа бол тэр нь ямар хууль юм бэ?” гэж эхэлдэг. Эдгээр олон асуултанд хариулснаар түүхийн гүн ухаан бүхэл бүтэн шинжлэх ухаан болон хөгжсөн байна.

Түүхийн нэр хүнд унасан тэр цагаас түүхийн гүн ухааны суурь асуудал болох историзмын зарчим үүсэж, хүн төрөлхтний түүхэн оршихуйг гурван цаг хугацааных нь нэгдэлд буюу өнгөрсөн, одоо, ирээдүйг нэгдмэл хэмээн үзэж ялангуяа өнгөрсөн, ирээдүй хоёр одоод чухал үүрэг гүйцэтгэдэг гэсэн санааг дэвшүүлж хэн ч үгүйсгэж чадахааргүйгээр баталсан байдаг. Ингэснээрээ историзм нь түүхийн гүн ухааны

бусад урсгалуудад нэгэн өвөрмөц өнгө аяс нэмсэнээр түүхийн ач холбогдлыг улам тодруулж өгчээ. Өнгөрснөө таньж мэдээгүй хүн өнөөдрийг таньж мэдэх боломжгүйн дээр маргаашийг ч баримжаалах чадваргүй байдаг. Энэ утгаараа түүхийн шинжлэх ухаан нь зөвхөн өчигдрийг судалдаг ухаан бус өнөөдөр, маргаашийг урьдчилан баримжаалж мэдэж байх ёстой гэсэн зарчмыг гаргаж тавьснаараа түүхийн нэр хүндийг байх ёстой хэмжээнд нь эргүүлэн тавьж чадсан байна. Одоо нь өнгөрсөнтэй холбоотой байх албагүй гэж үзэж байсан детерминизмийн урсгалын утга учиргүйг харуулав. Гэхдээ детерминизм нь түүхчид болон гүн ухаанчдыг хөдөлгөөнд оруулж чадсанаараа түүхэн ач холбогдолтой байсныг үгүйсгэж болохгүй юм. Историзмын зарчмын утга учрыг улам тодруулсан арга бол историцизм байлаа. Энд бид историцизмын олон аргуудыг нэг бүрчлэн ярих боломжгүй тул Гердерийн энэ чиглэлд дэвшүүлсэн санаа оноог товч дурьдаж болох юм. Гердерийн историцизм нь түүхийг бусад бүх нийгмийн шинжлэх ухааны дээгүүр тавьж, улмаар түүх нь гүн ухаан, хүний сэтгэлгээний үндэс буюу контекст нь мөн хэмээжээ. Тэрээр бусад шинжлэх ухаан түүхийг баримжаалж хөгждөг хэмээн үзэхийн зэрэгцээ историцизмд өндөр ач холбогдол өгч нийгмийн шинжлэх ухааны программ юм гэж тодорхойлсон байдаг. Гердерийн историцизм нь түүхэн үйл явцыг \энд түүхэн үйл явдлын талаар дурдаагүй гэдгийг тодруулах хэрэгтэй болов уу С.О\ өвөрмөц, аугаа, онцгой үзэгдэл гэж үздэгийн дээр аливаа юмс үзэгдлийг төрмөл чанарт нь суурилуулж ойлгохыг шаарддаг. Өнгөрснийг өнөөгийн эрин үеийн шалгуураар шалгаж ойлгохыг буруутгаж түүхэн судалгааны амин сүнс нь түүхэн контекст, \тухайн үед болсон үйл явц засваргүйгээр байх\ түүхэн холбоо хоёр гэж үзжээ. Товчоор хэлбэл, түүхэн үзэгдлийн утга санаа нь контексттэйгээ тохирч байх ёстой гэсэн зарчмыг гол болгосон байдаг. Ийнхүү Гердерийн историцизм нь историзмын үндсэн асуудалд өөрийн гэсэн хувь нэмрээ оруулжээ.

Историзм нь түүхийн нэр хүндийг ийнхүү өргөхийн зэрэгцээ өчигдрөө буруу ойлгосон бол өнөөдрийн хөгжил буруу гольдрол руу орох хийгээд маргаашийг таних боломжгүй болно гэж бас болгоомжлуулдаг. Өнгөрсөн түүхээ сайн мэдэж, зөв ойлгоогүй бол өнөөдрийг танин мэдэхэд муу үр дагавар авчирдаг гэжээ. Историзмын зарчмаар түүхийн шинжлэх ухааны үндсэн зорилт бол судлаж буй объектынхоо мөн чанарыг нэгдмэл үзэл дээр илэрхийлж гаргахад оршдог. Түүхийн шинжлэх ухаан нь үнэний мөн чанартай, түүхийн эрдэмтэн судлаачдын нэр их хөдөлмөр ч түүхийн факт, түүхэн үйл явцын үнэн мөн чанарыг тогтоохын төлөө байх ёстой. Түүхчийн энэхүү нэр их ажлын үр дүнд хүн төрөлхтөнд өнгөрсний тухай бодитой төсөөлөл бий болж ингэснээрээ ирээдүй үедээ өнгөрсөн үеэсээ үнэт зүйлсийг өвлөн эзэмших боломжийг олгодог байна.

Гегель түүхийн шинжлэх ухааны хөгжлийг 1. Анхдагч түүхийн үе, 2. Түүхийг шинжлэх ухааны үүднээс авч үзэх үе, 3. Түүхийг гүн ухааны үүднээс авч үзэх үе гэсэн гурван үе болгон авч үзсэн байдаг. Нэгдүгээр үе буюу түүхийг өөрийн үзсэн харснаар тэр чигээр нь буулгаж гаднаас нь харж харьцуулан дүгнэх аргыг огт хэрэглэдэггүй байсан үеийг анхдагч түүхийн үе хэмээн үзжээ. Энэ үеийн гол төлөөлөгчид нь Геродот, Фукидит нар юм гэжээ. Хоёрдугаар үе буюу түүхийг шинжлэх ухааны үүднээс үзэх үеийг тодорхойлохдоо бүх нийтийн түүх, прагматик түүх, шүүмжлэлт түүх гэсэн хэд хэдэн хэсэгт хувааж үзжээ. Энэ үеийг түүх бичигч тодорхой зарчим, түүх бичих арга барилд захирагдаж бичихийн дээр түүхт үйл явцыг бичих бус түүхийн түүхийг бичдэг хэмээн тодорхойлжээ. Мөн түүхэн том бүтээлүүдэд үнэлэлт дүгнэлт өгөх, үнэн мөнийг нь тогтоох гэж оролдох, зарим тохиолдолд өнгөрсөн түүхийг өнөөдөрт буулган дүгнэх хандлага илэрнэ. Гурав дахь үе буюу түүхийн гүн ухааны үед түүхч гүн ухааны зарчмыг баримталж түүхийг онолын үүднээс дүгнэж сэтгэн бодох, гүнзгийрүүлэн сэтгэх үүднээс хандах болно.

Энэ утгаараа нийгмийн бүхий л эд эсүүдийг бүхэлд нь нэгтгэн авч үзэхийн дээр хүн төрөлхтний хөгжлийн ерөнхий зургийг гаргана гэжээ.

Түүхийн гүн ухаан гэсэн бүхэл бүтэн шинжлэх ухаан үүсэж, дэлхий дахинд түүхийг үзэх шинэ үзэл төлөвшиж, их дээд сургуулиуд болон дунд сургуулиудад түүхийг цоо шинэ аргаар заах болсноор даруй нэгэн зууны нүүрийг үзжээ. Дэлхийн томоохон их дээд сургуулиудад түүхийг ямар түвшинд зааж байна вэ гэдгийг тодорхойлох гэж оролдохдоо илтгэгч Гегелийн үечлэлийг шалгуур болгон авч үзлээ. Дээр дурьдсанчлан түүхийн хөгжлийг

1. Анхдагч түүхийн үе
2. Түүх шинжлэх ухааны түвшинд хүрсэн үе
3. Түүхийн гүн ухааны үе

гэсэн Гегелийн үечлэлээр авч үзвэл түүхийн заах арга зүй нь цагираг хэлбэрээр, шат ахисан давтамжтайгаар улам боловсронгуй болж байгаа нь харагддаг. Тухайлбал түүхийн гүн ухаан нь түүхээр байнга цангаж байдаг. Энэ ч утгаараа түүхийг түүхийн гүн ухааны үүднээс заахдаа анхдагч түүхийг Геродот, Фукидитын үеэс нэг шат ахиснаар арай боловсронгуй болгож ашиглах болсон байна. Кэмбрижийн их сургуульд “Өвөр Монгол дахь мэргэ төлөг” сэдэвтэй лекц уншихдаа Америкийн эрдэмтэн анхдагч түүхийг ашиглаж уншсан жишээг энд дурдъяа. Тэрээр Өвөр монгол төлөгчийн төлөг буулгахдаа ашиглаж байсан толь, архи, хадаг гурвыг оюутнуудад үзүүлж хэрхэн хэрэглэж байсныг биечлэн үзүүлж мөн төлөгчийн төлөг буулгаж байгаа кино хальсыг үзүүлж байв. Ингэж анхдагч түүхийг ашигласны дараа энэ бүх үйлдлийг түүхийн гүн ухааны үүднээс тайлбарласан нь сонирхолтой байхын зэрэгцээ бодитой, өгөөжтэй байлаа. Энэ арга нь дэлхийн их дээд сургуулиудад нилээд түгээмэл хэрэглэгддэг болжээ. Түүхийн гүн ухаан нь түүхийн шинжлэх ухааны нэр хүндийг өргөхөд контекст чухал болохыг заасаар ирсэн. Хүмүүс өөрийн үзэж хараагүй зүйлсийн тухай бусдаас ам дамжуулан сонсдгийн нэгэн адил түүхч хүн өөрийн биеэр уншиж судлаагүй, гараар барьж үзээгүй зүйлсийн тухай амаар дамжуулан мэдээ маягаар ярихыг эрс хориглодог. Дээрхи их дээд сургуулиудад энэ л зарчмыг баримталдаг байна.

Манай ерөнхий боловсролын болон их дээд сургуулиудад Монголын түүхийг ямар шатанд зааж байна вэ? Үүнд хариулахын тулд эргээд Гегелийнхээ үечлэлийг ашиглая. Гегелийн үечлэлээр бол ерөнхий боловсролын сургуулиудад Монголын түүхийг анхдагч түүхийн үеэр зааж байна. Гэхдээ барууны орнуудад зааж байгаа анхдагч түүхээр бус харин Геродот, Фукидитын үеэр буюу он цагийн хэлхээс маягаар, зөвхөн мэдээлэл өгөх хэлбэрээр заах нь түгээмэл байна. Тухайлбал тэдэн онд тийм улс тогтож байв, тэдэн онд мөхөв гэх мэтээр. Энэ байдал нь түүхийн мөн чанарыг алдагдуулж, сурагчдын дунд түүхийн нэр хүндийг унагаахад хүргэж байна. Их дээд сургуульд элсэн орж байгаа оюутан залуус Монголын түүхийг арван жилд авсан ойлголтоороо үнэлж нойрны хичээл, нойрны эм гэж үзэх болсон нь нууц биш юм. Гэтэл Их дээд сургуульд Монголын түүхийг өнөөг болтол Гегелийн хоёрдугаар үе буюу шинжлэх ухааны түвшинд үзэх хандлагаар заасаар байна. XVIII зууны үед барууны орнуудад түүхийн шинжлэх ухааны нэр хүнд унаж байсан тэр үйл явц өнөөдөр Монголд давтагдаж байна. Энэ бол эмгэнэл. Учир нь аливаа үндэстэнг мөхөөе гэвэл түүх рүү нь довтол гэдэг. Энэ ч сургааль ёсоор улс орнууд бие биендээ хандсаар ирсэн байдаг. 1368 онд Монголын Юань улс унаж Тогоонтөмөр хаан Хаанбалгасан хотоосоо Монгол руугаа зугтахдаа алт мөнгөө авалгүйгээр 13 сүйх тэрэг монголынхоо түүх шастырыг авч зугтсан байдаг. Хятадууд Тогоонтөмөр хааны хойноос их хүч илгээлгүй 13 сүйх тэрэг монголын түүх шастир руу хүч түрсэн цэрэг илгээж, Өвөр Монголын хил дээр сүйх тэргийг гүйцэж очоод бүгдийг нь хорсолтойгоор шатаасан байхад 1960-аад оны эхээр ЗХУ монголын түүх рүү ил довтолох болж их, дээд сургуулиудад монголын түүх заахыг

хориглож оронд нь ЗХУКН, МАХН-ын түүхийг марксист-ленинист онолд тулгуурлан заах мөн дунд сургуулиудад монголын түүхийн хичээлийн цагийг хязгаарлах зааварчилгааг өгч байсан жишээг энд дурьдаж болох юм. “Түүх бидэнд алхам газрын үнэ цэнийг яс маханд маань тултал ойлгуулж эх орноо хайрлах тэр их агуу сэтгэлийг, зүтгэлийг өгдөг үнэт зүйл юм.” (С.Отгонжаргал Түүх мөн чанар ухаарлын мэлмий. УБ. 2004 х.8)

Гэхдээ бидэнд үүнээс гарах арга зам нээлттэй байгааг хэлэх нь зүйтэй болов уу. Өнөөгийн оюутан залуучууд, сурагчдад Монголын түүхийг түүхийн гүн ухааны үүднээс заах шаардлага хойшлуулашгүй чухал байгааг тэмдэглэх хэрэгтэй юм. Энэ шаардлагыг хангахын тулд их дээд сургуулиудын түүхийн ангиудад түүхийн гүн ухааныг заавал үзэх хичээл болгож кредитыг нь нэмэх нь зүйтэй мэт санагддаг. Ингэснээр шинээр бэлтгэгдэж буй түүхчид судалгааны ажил хийхдээ бүтээлээ түүхийн гүн ухааны үүднээс хандаж туурвих болно. Мөн дунд сургууль, их дээд сургуульд хичээл заахдаа ч түүхийн гүн ухааны үүднээс хандан заах болно. Ингэж Монголын түүхийн заах арга зүйг нэг шат ахиулснаар Монголд түүхийн шинжлэх ухааны нэр хүнд зохих байр сууриа эзлэх эхлэл тавигдах юм.

Түүхэн үйл явдлыг түүхийн гүн ухааны үүднээс тайлбарлаж түүхэн үйл явц мөн болохыг нотолсон ганцхан жишээг энд дурьдаяа.

“Нууц товчоо”-нд: “Хэрлэн мөрний эх Бүрги эрэгт нутаглан байтал нэгэн өглөө Өүлэн эхийн гэрт зарцлагдах Хуагчин эмгэн босож өгүүлрүүн: “Эх, эх үтэр бос. Газар дэлбэрэх мэт чимээ гарч, морины төвөргөөн сонстоно. Аймшигт Тайчууд айсуй биз” гэв. Өүлэн эх: “Хөвүүдийг даруй сэрээгтүн” гээд өөрөө даруй босов. Тэмүүжин нар даруй босоод морьдоо барьж Тэмүүжин, Өүлэн эх, Хасар, Хачиун, Тэмүгэ, отчигин, Бэлгүтэй, Боорчи, Зэлмэ нар тус бүр нэг морь унаж Тэмүлүнийг Өүлэн эх өвөртөө дүүрэв. Нэгэн моринд юм ачиж хөтлөв. Бөртэ Үжинд морь дутав” (Монголын нууц товчоо. УБ.1990.х.55) гэж Бөртэ Үжинийг Мэргэдүүдэд алдсан **үйл явдлын** тухай тэмдэглэн үлдээжээ. Америкийн эрдэмтэн Жек Ведерфорд “Өнөөгийн ертөнцийг үндэслэгч эзэн Чингис хаан” номондоо Чингис Бөртэ Үжинээ чухам яагаад хаяад явсан талаар түүхийн гүн ухааны аргаар тайлбар хийхийг оролдсон байдаг. Тухайлбал “Өүлэн эх” гэсэн дэд гарчигтаа: “Бага охиноо дүүрэн уул руу дутааж яваа Өүлэн дөнгөж дөч гарч яваа бөгөөд насаар ахмад нь биш ч, найман хүүхдийн тавынх нь эх учир гэр дотроо хамгийн их эрх мэдэлтэй нь байв. Нэгийг нь ч болов мордуулах хөтөлгөө морьтой хэрнээ нөгөө гурваа хэн нь чухам юуны учир орхисныг хэн ч эс мэднэ. Гэвч энэ агшин зуурын шийдвэрийг гаргасан хүн нь Өүлэн байхаас зайлахгүй. Тэр ямар хүмүүс халдан ирж байгааг таньж, тэднийг зайлуулахын тулд бэрээ орхижээ. Залуу бэр байхдаа тэр өөрөө яг энд нөхрөөсөө булаалгасан учир нөхцөл байдлыг бусдаас илүүтэй ойлгож байв. ... Хорь ч хүрээгүй тэр нөхрийнхөө амийг аврахын тулд өөрөө тэдэнтэй нүүр тулан учрахаар шийдэж хоцорч байсан. Хэрэв тэр нөхрөө дагаж зугтвал, нөхөр нь амиа алдах ... харин үлдэж хоцорвол нөхөр нь амь гарч, зөвхөн өөрөө л баригдах байлаа” гэжээ. Жек Ведерфорд. “Өнөөгийн ертөнцийг үндэслэгч эзэн Чингис хаан” УБ.2005.х.18”19 Жек Ведерфорд Чингист тохиолдсон энэхүү нэгэн агшныг субстантив түүхийн гүн ухааны аргаар маш чадамгай тайлбарлажээ. Бөртэ Үжинийг алдсан явдлыг мэдээлсэн Нууц товчооны мэдээг Гегелийн баримжаалан сэтгэх диалектик аргаар **үйл явц** байсан гэдгийг үгүйсгэх аргагүйгээр баталжээ.

Өнөөгийн залуучуудад Бөртэ Үжинийг хаяад явсан мэдээ чухал бус, харин энэ үеийн субстанц болсон Тэмүүжин хүүг аварснаар Бөртэг ч аварч болно гэсэн Өүлэн эхийн “Ухаан”-ыг ойлгуулах нь хамгийн чухал юм. Есүгэй баатар Өүлэн эхийг Мэргэдийн Чилэдүгээс булааж авсан нь үнэн. Мэргэдүүд хэзээ нэгэн цагт хариугаа авах байсныг Өүлэн эх тооцон мэдэж байсан. Ийм ч учраас Бөртэг

булаахаар ирсэн Мэргэдүүдийн **үйлдэл** нь санаандгүй тохиолдол бус түүхэн **үйл явц** байсан юм гэдгийг ойлгуулах нь түүхч хүний үүрэг байдаг байна. Үүнээс үзэхэд, түүхийг он цагийн хэлхээс, үйл явдлын мэдээ болгон заахаасаа илүү түүхэн үйл явц гэсэн үүднээс зааж өчигдрийн үнэт зүйлсийг өнөөдөрт дамжуулан ухааруулах шаардлагатай байна. Жек Ведерфорд Тэмүүжинд тохиолдсон нэгэн үйл явдлыг түүхийн гүн ухааны үүднээс үйл явц болгон тайлбарласны зэрэгцээ тухайн үйл явц болсон газар нь болох Монгол Улсын Хэнтий аймагт ирж судалгаа хийжээ. Хуагчин эмгэн олон морьтон ирж байгааг урьдчилан мэдсэн нь өрнөдийн уншигчдад оньсого мэт ойлгомжгүй тул тэрээр арваас дээш тооны морьд алсаас давхиулан газар дээр төмпөн тавьж чагнаж үзсэн тухайгаа тодорхой бичсэн нь сонирхол татаж байгаа юм. Ж.Ведерфорд контекстээ улам лавшруулж: “бид Өүлэний хүүхдүүдтэйгээ зугтаж явсан замаар гол дагаж өгссөөр нилээд ахивал тэр гол нь горхи болон нарийсч ууланд хүрэв. Энэ зэлүүд уул шиг унаган төрхөөрөө байгаа газар, дэлхий дээр тун ховор биз гэсэн бодол өөрийн эрхгүй надад төрсөн юм. Нийслэл Улаанбаатар хотоос зүүн зүгт хоёрхон өдрийн газарт 160 км байх энэ нутаг Тэмүүжин, Өүлэн нарын амь хоргодож байсан үеийнх шиг онгон байгалаа хадгалан үлджээ. ... Уул руу өгсөж явах замд эхлээд, зүлэг ногоотой тал байснаа сондуул элбэгтэй болж, дараа нь мод бургас ихтэй газар болов ... зарим хэсэгтээ унасан мод ихтэй, өтгөн шугутай, монголчуудын хэлдгээр ёстой л цатгалан могой ч шургаж орохын аргагүй шигүү байлаа.” 160-210 км гэж Өүлэн болон түүний хүүхдүүд тэр олон цэрэгт баригдаагүйн учрыг өөрийн үзсэн харсанаараа тайлбар өгсөн байдаг. Тэрээр түүхийн гүн ухааны шаарддаг контекстийн асуудал буюу анхдагч түүхийн асуудлыг ийн давхар шийдсэн байна. Ж.Ведерфордын Чингисийн тухай бичсэн ном хэвлэгдэн гарсан даруйдаа нэр алдар олж, олон оронд хэвлэгдэж мянга мянган хүний амтархан уншдаг ном болсны учир нь түүхийн гүн ухааны үндсэн зарчмыг барьж бичсэнтэй салшгүй холбоотой юм. Түүхийн гүн ухааныг заах ёстой төвшинд нь зааж олон арван түүхчдийг бэлтгэх аваас Монголд түүхийн шинжлэх ухааны нэр хүндийг зохих байранд нь тавих өргөн боломж байсаар байна.

Abstract. In this article the author tried to prove on a theoretical basis that the philosophy of history is the only possibility to raise the prestige of Mongolian history and attempted to define the level of teaching Mongolian history at general educational schools and universities.